

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн журмуудын танилцуулга

Холбоо барих:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний ахлах менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Отгонтогтоолын Мөнхнасан

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhnasan.otgontogtool@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
605 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn



Хураангуй

2022 оны 12-р сарын 19-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг (“ТХХТХ”) баталсан бөгөөд 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. ТХХТХ-ийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12-р сарын 04-ний өдөр 210 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн хүрээнд дараах журмуудыг баталсан байна. Үүнд:

1. Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам;
2. Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам;
3. Түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах журам;
4. Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам;

Энэхүү хууль эрх зүйн мэдээллээрээ дээрх журмуудын талаарх товч мэдээллийг та бүхэнтэй хуваалцаж байна.



Батлагдсан журмууд

1. Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам (“Үнэлгээний журам”)

Үнэлгээний журмаар ТХХТХ-д заасан түншлэлийн төслийн хүрээнд аймаг, нийслэлд хэрэгжүүлэх төслийн ач холбогдол, үр ашгийг нарийвчлан судалж тогтоох, хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт гаргах, аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, түншлэлийн төрөл, гэрээний хэлбэрийг тодорхойлох зорилгоор түншлэлийн төслийн төлөвлөлтөд урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Тус журмын дагуу хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад гаргах бөгөөд санал нь журамд заасан төслийн мэдээлэл, танилцуулгад тавигдах шаардлагыг хангасан байх ёстой. Засаг дарга нь төслийг хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар урьдчилсан үнэлгээг хийнэ. Урьдчилсан үнэлгээ хийгдсэн, аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээг хийх бөгөөд Үнэлгээний журмаар бүрэн шинжилгээ хийх, үнэлэх ажиллагааны үе шат, төслийн багийн бүрэлдэхүүн, холбогдох зардал зэргийг тусгайлан зохицуулсан. Мөн төслийн баг нь төслийн урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, эх төслийг боловсруулна. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төслийг түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулахаар журамд тус тус заажээ.

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхгүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.



PwC Legal
A multidisciplinary law firm



Батлагдсан журмууд

2. Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам (“Сонгон шалгаруулах журам”)

Сонгон шалгаруулах журмаар түншлэлийн төслийн хүрээнд аймаг, нийслэл түншлэлийн төсөл хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийх, болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулна. Аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг төсөл тус бүрээр байгуулах бөгөөд уг ажлын хэсэг нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах юм.

Дээрхээс гадна, Сонгон шалгаруулах журмаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүний зохион байгуулалт, ажиллах журмыг нарийвчлан тусгасан. Мөн, тус журмын хавсралтаар “Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг үнэлэх заавар”, “Уралдаант шалгаруулалтын төслийн саналыг үнэлэх заавар”, “Хувийн хэвшлийн түншлэгч сонгох урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичиг”, “Хувийн хэвшлийн түншлэгч сонгох уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг” тус тус баталжээ.

3. Түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах журам (“Гэрээ байгуулах журам”)

Гэрээ байгуулах журам нь түншлэлийн төслийн хүрээнд аймаг, нийслэл нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна. Тус журмын дагуу түншлэлийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төслийн дагуу гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч гэрээний төрлийг тодорхойлно. Түншлэлийн гэрээний талууд нь төрийн түншлэгч талаас аймаг, нийслэлийн Засаг дарга, нөгөө талаас хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани, төслийн санхүүжүүлэгч хуулийн этгээд байна. Мөн, түншлэлийн гэрээний төрөл, нөхцөл, талуудын эрх, үүрэг, гэрээний хяналт, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, сунгах, цуцлах зэрэг харилцааг тус журамд заасан байна.

Дээрхээс гадна, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж, гэрээ байгуулахаар заасан түншлэлийн гэрээг аймаг, нийслэлийн Засаг дарга хувийн хэвшлийн түншлэгчтэй байгуулах талаар нарийвчлан зохицуулсан.

4. Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам (“Хяналтын журам”)

Аймаг, нийслэлийн хэрэгжүүлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон түншлэлийн төслийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг Хяналтын журмаар зохицуулна. Тус журамд заасны дагуу түншлэлийн гэрээнд талууд гарын үсэг зурж, хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түншлэлийн төслийн хэрэгжилтийг хангаж эхлэх ба хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий байгууллагаас авах үүрэгтэй. Мөн, хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ТХХТХ-д заасан эх үүсвэрээр санхүүжүүлэх бөгөөд санхүүжилтийг түншлэлийн гэрээнд заасан хугацаанд бүрдүүлэх үүрэгтэй талаар тусгажээ. Дээрхээс гадна, түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, түншлэлийн гэрээний биелэлт, гүйцэтгэлийн үнэлгээг хийх, тайлагнах үүрэг зэргийг тус журамд тусгасан байна.



Бидэнтэй холбогдоорой!

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох журмуудтай холбоотой хууль зүйн зөвлөгөө авахыг хүсвэл бидэнтэй холбогдоорой. **Батлагдсан журмуудтай энд дарж танилцана уу.**

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.



PwC Legal
A multidisciplinary law firm